



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/449

Улаанбаатар хот

Зөвлөмж хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын а, 29.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 05 дугаар сарын 30-ны 104 дүгээр зарлигт тус тус заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, нормативыг хүн амын тоо, бусад нөлөөлөх үзүүлэлтийг харгалзан шинэчлэн тогтоох саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх, согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хуваарийг богиносгох, долоо хоног бүрийн нэг өдрийг архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй, худалдан борлуулахгүй байх, 400 мл хүртэлх жижгээр савласан архи дэлгүүрээр зарахыг хориглох асуудлыг судалж, шийдвэрлүүлэхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд;

2. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигт дурдсан чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /А.Даваажаргал/, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс /Б.Эрдэнэчимэг/, Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т;

3. Болзошгүй эрсдэлээс амь нас, эрүүл мэндээ хамгаалж, өөрийн болон бусдын амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэхэд хариуцлагатай байх чиглэлээр хууль, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд олон нийтэд сурталчлахыг нийслэлийн нутгийн захиргааны захиргааны байгууллагуудад;

4. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т;

5. Нийслэлийн гэр болон орон сууцны хороололд гал унтраах аврах ангийн бие бүрэлдэхүүн, эмнэлгийн түргэн тусламжийн автомашин хүрэлцэн очиж үүрэг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, зам гарцыг чөлөөлөх, хаягжилт, координацитай болгох ажлыг 2019 оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлэхийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /А.Энхманлай/, нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар /Б.Ууганбаяр/-т, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар /С.Төмөрдулам/, Замын хөдөлгөөн, төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар /С.Энхтөр/;

6. Ажил олгогч, бизнес эрхлэгчид ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, ажилтнуудыг сургаж дадлагажуулах, иргэдийг гамшиг ослоос өөрийгөө болон бусдыг авран хамгаалах ажиллагаанд сургаж дадлагажуулах, амьдралын зөв дадал эзэмшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхийг Нийслэлийн Онцгой байдлын газар /Ж.Чүлтэмсүрэн/, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар /П.Батхүлэг/;

111100003477

7. Нийслэлийн хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлуудыг судалж, судалгаанд үндэслэн сэтгэлзүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх, иргэдийн нас баралтад нөлөөлж байгаа өвчин, эмгэгийн байдалд дүгнэлт хийн өвчлөлийг бууруулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т;

8. Эмийн худалдаа, чанар, хадгалалт, эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, шаардлагатай арга хэмжээ авахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т;

9. Бизнесийн орчинд хүүхдийн аюулгүй байдал, хамгааллыг хангах, бүтээгдэхүүн үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж, хүүхдийн эрхийг дээдэлж, дэмжсэн маркетинг, сурталчилгааг ашиглах, хүүхдэд зориулсан хүнс, хийжүүлсэн ундааны маркетингийг хязгаарлах эрх зүйн зохицуулалт бий болгох ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулахыг Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт;

10. Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т тус тус даалгасугай.

11. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Э.Содномжамц/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН